



ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН ТӨВ

Хэнтий аймаг

ЗӨСТ нь байгалийн голомтот болон зоонозын халдварт өвчний эрсдэлт хүчин зүйлийг тандан судлах, хянах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах, лабораторийн тусламж үйлчилгээ үзүүлэх, зоонозын хүний өвчлөлийн, тохиолдол дэгдэлтийн үеийн эрт сэрэмжлүүлэх хариу арга хэмжээг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулж, мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажилладаг.

Эрхэм зорилго

Түүхэн замнал

Үе үеийн
удирдлагууд

Бүтэц, зохион
байгуулалт

Хамт олон

Үйл ажиллагаа

ХАЯГ:

Хэнтий аймаг, Чингэс хот,
Хэрлэн сум, 2-р баг,
Тэмүүжингийн гудамж

Утас: 70563739

Цахим шуудан:

khentii@yahoo.com

Эрхэм зорилго

Зоонозын болон сэргэн тархаж байгаа халдварт өвчнүүдээс хүн амыг хамгаалах, халдварын тархалтыг таслан зогсоох, цомхотгон дарах

Түүхэн замнал

БНМАУ-ын сайд нарын зөвлөлийн 1943 оны 10-р сарын 20-ны 75-р тогтоолоор Хэнтий аймгийн төвд “Тарваган тахал эсэргүүцэх станц”-ыг байгуулахаар шийдвэрлэж, 1944 оны 7-р сард Оросын мэргэжилтэн, амьтан судлагч, доцент А.Г.Банниковын удирдлагаар “Тарваган тахал эсэргүүцэх станц”-ын суурь тавигдаж, аймгийн Цэцэнханы сүм (Одоогийн Сэцэнханы өргөө музей)-д байрлаж, 18 хүний орон тоотой байгуулагдсан. 1950, 1960 онуудад 2 удаа Дорнод аймагт шилжин байршиж байсан. 1980 оноос Хэнтий аймагт шилжин байршсанаас хойш одоог хүртэл үйл ажиллагаагаа явуулж байна.

Түүхэн хугацаанд тус төвийн нэр дараах байдлаар өөрчлөгдөж ирсэн байна. Үүнд:

1944-1960 он - Тарваган Тахал Эсэргүүцэн Судлах станц

1961-1979 он - Дорнод аймаг дахь Гоц Аюулт Халдварт Өвчнийг Эсэргүүцэн Судлах аймаг дундын станц

1980 -1987 он -Хэнтий аймаг дахь Гоц Аюулт Халдварт Өвчнийг Эсэргүүцэн Судлах аймаг дундын станц

1988 -1989 он - АЦХССтанцын ГАХӨ-ний хяналтын тасаг

1990 -2005 он - Байгалийн Голомтот Халдварт Өвчинтэй Тэмцэх Газар

2006-2011 он - Байгалийн Голомтот Халдварт Өвчин Судлалын Төв

2012 оноос Зоонозын өвчин судлалын төв




Байгууллагын анхны байр



Шинээр баригдаж байгаа байр

Үе үеийн удирдлагууд



1944 он
А.Г.Банников
ЗХУ-ын ШУА-
академич



1965 -1967
1982-1984
Ж.Дэмбэрэл




1965 -1982 Ангаах
ухааны доктор
Д.Батсүх



1984 Анагаах
ухааны Доктор
Ч.Дангаа



1984-1987
С.Намид



1987-1989
Л.Баатартөмөр



1989
Н.Лувсанжамбаа




1986 оноос
Биологийн ухааны магистр
Г.Наранхүү

Үйлчлэх хүрээ

- 1944 -1990 онд зүүн бүсийн аймгуудад үйлчилж байсан.
- 1990 оноос Хэнтий аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байна.

Бүтэц зохион байгуулалт



Манай хамт олон

- 1977-1978 онд Дорнод аймгийн ЭХБ-ын хэмжээнд 1,2 дугаар байр, ГАХӨЭС системийн хэмжээнд 3-р байр,
- 1979 онд Г.Дамдинсүрэн ахлагчтай “Социалист хөдөлмөрийн бригад “ цол
- 1982 онд Д.Батсүх даргатай хамт олныг байгууллагын засвар тохижилтыг үлгэр жишээ гүйцэтгэсэн учир аймгийн АДХ-ын гүйцэтгэх захиргааны тэргүүлэгчдийн шийдвэрээр ЗИЛ-130 машинаар шагнасан.
- 1983 онд Ж.Дэмбэрэл даргатай хамт олон аймгийн 60 жилийн ой угтсан тохижилтын аянд 2-р байр эзэлсэн.
- 1985 онд С.Намид ахлагчтай “8-р таван жилийн гавшгайч хамт олон”
- 1996, 1999, 2006, 2012 онд БГХ өвчинтэй тэмцэх байгууллагуудын аварга хамт олон
- 2002, 2008 онд Хэнтий аймгийн шилдэг төрийн байгууллага
- 2002 онд ЭМБ-уудын хөдөлмөрийн аварга хамт олноор шалгарч байсан.

ХАМТ ОЛОН



Үйл ажиллагааны зурагт агшин



